**ХБТХОХ-ИЙН ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН АЖИЛТАН Д.СҮГЛЭГМААГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /ЭХНИЙ ХАГАС ЖИЛ/**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | 1.1. Аймгийн Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.2.1 дэх заалтын хэрэгжилтийг хanган ажиллах, тайлагнах | Холбогдох арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 30.0 хувь | Холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг 50-аас доошгүй хувь хангаn ажилласан байна. | -ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн бүрэлдэхүүн Үерийн менежментийн хэсгийн худалдан авах ажиллагаа амжилттай зохион байгуулагдаж, шалгарсан компани Хунан Индастриал Икүпмент Инсталашн ХХК-тай гэрээ байгууллаа. Гүйцэтгэгч компаниуд төслийн талбайд нүүж ирж, түр кемп байгуулан, бетон зуурмагийн үйлдвэрийг байгуулсан. Ажил эхлүүлэх зөвшөөрлийг тус бүр авчбарилгын ажлыг эхлүүлээд байна. -Гүйцэтгэгч компаниудын урьдчилгаа төлбөрийн, гаалийн татвараас чөлөөлүүлэх болон дотоодоос худалдан авах бараа, материал, үйлчилгээний татвараас чөлөөлүүлэх хүсэлттэй холбоотой баримт баримт бичгүүдийг | 2025-01-02 2025-06-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох журмын дагуу Сангийн яама нд хүргүүлэн шийдвэрлүүллээ.<br>-Төслийн үйл ажиллагааны, Байгаль орчин, нийгмийн, санхүүгийн болон бусад тайлангуудыг зөвлөхүүдтэй хамт боловсруулан Банк, СЯ-нд хүргүүлэв.<br>-Төслийн болон гүйцэтгэгч нартай холбоотой мэдээллийг СЯ-ны “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем” /ODAMIS/-д шивж оруулсан.<br>-Төслийн ТУХ-ын хурлыг зохион байгуулж, ТХН-ийн 2024 оны үйл ажиллагааны аудитын дүгнэлт, гүйцэтгэгч компаниудын НӨАТ-аас чөлөөлүүлэх дотоодоос худалдан авах бараа, материал, үйлчилгээний жагсаалтыг батлуулах зэрэг асуудлыг хэлэлцүүлсэн.<br>-Төслийн хүрээнд Эрдэнэт Ус ОНӨХК-д хэрэгжүүлсэн Компанийн чадавхийг сайжруулах хөтөлбөрийн хугацааг сунгахтай холбоотой албан бичиг, гэрээний нэмэлт өөрчлөлт зэргийг боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн.<br>-Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд хийгдсэн дотоод аудитын үнэлгээгээр нэгжийн ажилтнуудтай хийсэн хөлсөөр ажиллах гэрээг сунгахгүй шийдвэр гарсан. Үүний дагуу ТХН-ийн ажилтнуудын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлан, ТХН-ийн шинэ бүтэц, орон тоог  СЯ-аар батлуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Төслийн зээлийн санхүүжилт авах хугацаа дуусч байгааг сунгуулах албан бичгийг СЯ, ЕСБХБ-нд хүргүүлэн шийдвэрлүүлсэн.<br>- Төслийн барилгын ажил эхэлж байгаатай холбогдуулан төслийн нээлт, шав тавих ёслолыг төслийн зөвлөх, Банктай хамтран зохион байгуулсан. | | |
| 2. | 1.2. Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан холбогдох арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хувь | 70.0 хувь | Арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Төслийн хугацааг сунгасантай холбоотой төслийн ажлыг урагшлуулах төслийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг ирүүлэх талаар төслийн гүйцэтгэгч талд болон БНПУ-аас монгол улсад суугаа Элчин сайдад албан бичиг хүргүүлсэн. Төслийн ажил дуусаагүй тул санхүүжилтийг дараа жил болгон хойшлуулах тухай албан бичгийг Сангийн яаманд хүргүүлээд байна. Төслийн гүйцэтгэгч талд ажлаа хийхийг шаардсан албан бичиг дахин хүргүүлсэн. Төслийн гүйцэтгэгч талтай хамтран ажиллах ажлын хэсэг 4 удаа хуралдсан ба төслийн талбайд 2 удаа ажилласан. Төслийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх, гүйцэтгэгч талыг төслийн талбайд ирж ажиллахыг шаардаж байгаа. | 2025-01-02<br>2025-06-06 | 70% |
| 3. | 1.3. Аймгийг хөгжүүлэх 2025 оны жилийн төлөвлөгөөний | Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хувь | Арга хэмжээнүү-дийн хэрэгжилтийг | Аймгийг хөгжүүлэх 2025 оны жилийн төлөвлөгөөний | 1. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Монгол улсын ногоон, хүртээмжтэй хотууд" төслийн баримт бичгийг | 2025-01-02<br>2025-06-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 4.3.1.7.-т тусгагдсан олон улсын байгууллагууд болон харилцаа, хамтын ажиллагаат гадаад орнуудын муж, хотуудтай нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд холбоотой арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллах | | ханган ажилласан. | холбогдох заалтын хэрэгжилтийг ханган ажилласан байна. | боловсруулах баг аймагт ажиллахад хамтран ажиллаж, хуралд оролцов.<br><br>2. Эрдэнэт хот, Тоокомачи хотын хамтын ажиллагааны хүрээнд Залуучууд солилцооны арга хэмжээнд оролцох хүүхэд, залуучуудыг сонгон шалгаруулах ажлын хэсэгт ажиллан сонгон шалгаруулалтын удирдамж боловсруулах, сонгон шалгаруулалтыгүе шаттай явуулах, үнэлгээ хийж хөтөлбөрт хамрагдах сурагдыг сонгох ажлуудад оролцлоо.<br><br>3. ИКЛЭЙ – Тогтвортой хөгжлийн төлөөх нутгийн захиргаадын олон улсын байгууллагын “Шинжлэх ухаанд суурилсан ногоон шилжилт 2025” олон улсын хотуудын захирагч нарын дээд хэмжээний уулзалтад оролцлоо. Монгол улсаас Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын төлөөллүүд оролцож, дэлхийн хотуудын тогтвортой хөгжлийн төлөө, байгальд түшиглэсэн, тойрог эдийн засгийг дэмжсэн, тэгш хүртээмжтэй хотыг бүтээж байгаа туршлагуудыг судаллаа. | | |
| 4. | 1.4. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай | Хөтөлбөр, төслийн хөрөнгө оруулалтын мэдээ, мэдээний | Холбогдох хөтөлбөр, төслийг боловсруулан хэрэгжүүлэн | Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж, | Орхон аймагт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийн тайланг 2024 оны эцсийн байдлаар нийт 11 хүснэгтээр нэгтгэн гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлтийн | 2025-01-02<br>2025-06-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын мэдээллийг тухай бүр гарган холбогдох газар хүргүүлэх, удирдлагуудыг мэдээллээр ханган ажиллах | орчуулгын тоо хэмжээ | ажилласан байна. | тайлагнасан байна. | хамт Сангийн яаманд тайлант хугацаанд хүргүүлэв.<br><br>- Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн албаны ажлын хэсэг Орхон аймагт ажиллаж төслийн хэрэгжилт явцын талаар холбогдох хүмүүсээс мэдээлэл авч баримт материал бүрдүүлэн ажиллахад хамтран ажиллаж шаардлагатай мэдээллийг бэлтгэж өгсөн.<br><br>- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр барих, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах” төслийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн Ерөнхий хянан шалгагчийн албан шаардлагын хариуг хугацаанд нь хүргүүлсэн. 2025 оны 01 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд ажлын хэсэг аймгийн ЗДТГ-т дахин ажиллаж албан шаардлагын хариуны дагуу гүйцэтгэлийн хяналт шалгалт хийв. Энэ хүрээнд албаны хүмүүс төслийн талбайд ажиллах, холбогдох хүмүүстэй уулзалт хийх ажилд хамтран ажиллав.<br><br>Төслүүдтэй холбоотой цаг үеийн мэдээллийг тухай бүр дотоод сүлжээгээр, биечлэн ярилцах болон ЗДЗХурлаар удирдлагуудад мэдээлэл хүргэж ажиллав. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | 1.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газраас гаргасан зөвлөмж, тогтоол, журмуудын дагуу гадаадын зочин төлөөлөгчид орон нутагт ажиллах үеийн тэмдэглэл хөтлөн зохих газар хүргүүлэх | Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан байна. | Салбарын чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан байна. | Гадаадын зочид төлөөлөгчид орон нутагт ажиллах тухай бүр тэмдэглэл хөтөлсөн байна. | Төслийн нээлтийн үйл ажиллагаатай холбогдуулан Европын холбоо, Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас ирсэн төлөөлөгчид аймгийн удирдлагуудтай хийсэн уулзалт болон төслийн гадаад зөвлөхүүд ирж ажилласан болон гадаад мэргэжилтнүүдтэй цахим уулзалт хийсэн тухай тэмдэглэл тус тус хөтөлсөн. | 2025-01-02<br>2025-06-06 | 100% |
| **Зорилт 2. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| 6. | 2.1. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах | Үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан байна. | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 100 хувь биелүүлэн ажилласан. | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 100 хувь биелүүлэн ажилласан байна. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хурлаар “Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтийн тайлан” хэлэлцэхэд “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр барих, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах” төслийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл бэлтгэж оролцов.<br><br>Хойд бүсийн зөвлөлийн хурал болохтой холбоотой БОУАӨЯ-ны цахим хуралд оролцож, “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр барих, хог хаягдлыг татан зайлуулах | 2025-01-02<br>2025-06-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | менежментийг сайжруулах" төслийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл бэлтгэж оролцов. | | |
| 7. | 2.2. Хэлтсийн хариуцах чиглэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шийдвэр гаргуулахаар тавьсан асуудлыг судалж, шийдвэрлүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах | Хамтран ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн байна | Холбогдох хууль дүрмийн хүрээнд асуудлыг шийдвэр лүүлэн ажилласан. | Холбогдох хууль дүрмийн хүрээнд асуудлыг шийдвэрлүүлэн ажилласан байна. Хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлд хяналт тавьсан байна | Хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд 32 албан тоот, мэдээлэл боловсруулж холбогдох газруудад шийдвэрлүүлэхээр хүргүүлэн ажиллалаа. Мөн ажлын чиг үүргийн хүрээнд удирдлагаас шилжүүлсэн 38 бичгийг шийдвэрлэж, хяналтанд авсан. | 2025-01-02<br>2025-06-06 | 100% |
| **Зорилт 3. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 8. | 3.1.ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлт, албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн байна. | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан ба биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж байна. | 2025-01-02<br>2025-06-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | | | | |
| 9. | 3.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллана. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2025-01-02 2025-06-06 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/Д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Ажлын хэсэг, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах | Үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан байна. | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 100 | Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг 100 хувь биелүүлэн | ЗДТГ-ын ХАБЭА-н зөвлөлд ажиллаж, зөвлөлийн ээлжит хуралд оролцож ХАБЭА-н зөвлөлийн жилийн ажлын | 2025-01-02 2025-06-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хувь биелүүлэн ажилласан. | ажилласан байна. | төлөвлөгөөг хэлэлцэн батлуулсан.<br><br>Бүх нийтээр мод тарих ажилд оролцож вокзалын ууланд хэлтсийн мэргэжилтнүүдийн хамт мод тарьлаа.<br><br>Хойд бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтад ажиллав.<br><br>“Хойд бүс – Эрдэнэт 2025” 5 дахь удаагийн эдийн засгийн форумын ажлын хэсэгт ажиллав. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх** | | | | | | | |
| 1. | 2.1. Шинээр батлагдсан хууль тогтоомжийг судалж, үйл ажиллагаандаа ашиглах, төрийн албаны тухай хуульд заасны дагуу багц сургалтад хамрагдсан байх | Судалсан хууль, тогтоомж, хамрагдсан сургалтууд | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого”-ыг зорилго | Хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулсан байна. | Салбарын болон холбогдох чиглэлээр хууль, эрх зүйн мэдлэгийг бие даан сайжруулж байна.<br><br>Ажлын шаардлагын хүрээнд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/30 дугаар тушаалын хавсралт “Хүмүүнлэгийн болонбуцалтгүй | 2025-01-02<br>2025-06-06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зорилтыг төрийн албан хаагчдад таниулах сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. | | тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа, ажил, үйлчилгээг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах журам"—ыг судаллаа.<br><br>-АТГ-аас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан. | | |
| 2. | 2.2. Гүйцэтгэж буй ажлын чиглэлээр мэдлэг, чадвараа дээшлүүлэх | Салбарын чиглэлийн сургалтууд | Сургалтад хамрагдсан. | Сургалтад хамрагдсан байна. | -И-оффисын шинэчлэл сургалт<br><br>- ХАБЭА-н ажил олгогч, удирдах ажилтны 8 цагийн сургалтад хамрагдсан. | 2025-01-02<br>2025-06-06 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН: /Д.Сүглэгмаа, гадаад зээл тусламж, төсөл хөтөлбөр хариуцсан ажилтан/